

Байгууллагын товч танилцуулга:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.

Бодлогын уялдаа:

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд:

Монгол Улс дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагыг өөрийн орны өвөрмөц онцлогтой уялдуулан хөгжлийн бодлогын баримт бичгээ батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал 1998 онд “Монгол Улсын 21-р зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, 2005 онд “Мянганы хөгжлийн зорилгууд”, 2014 онд “Ногоон хөгжлийн бодлого” болон 2020 онд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн, 2018 онд Монгол Улсын Засгийн газар “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлогын зорилт:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд эх байгаль анхдагч экосистем, байгалийн баялгийн үр өгөөж, үнэт баялаг ус болон хүртээмжтэй ногоон өсөлтийн талаар зорилго, зорилт дэвшүүлэн хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Түүнчлэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих, байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр тусгасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдааг ханган ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн боловсрол салбарын бодлогын баримт бичигтэй уялдах нь:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд:

Зорилт 6.2. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.

- 6.2.15. Байгаль орчны мэдээллийн төвийн үйл ажиллагааг нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаатай уялдуулан олон нийтэд байгаль хамгаалал, уламжлалт ёс заншлын мэдлэг, тогтвортой хөгжлийн боловсрол олгоно.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд:

- 2.3.4. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2020 оны байдлаар байгаль орчныг хамгаалах, газар, ус, байгалийн ургамал, ой, ан агнуур, агаар, хог хаягдал, химийн бодис,

аялал жуулчлал зэрэг 36 хууль, 22 Олон Улсын гэрээ конвенц, Ногоон хөгжлийн бодлого, Төрөөс ойн талаар баримтлах бодлого, Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримтлах бодлого гэсэн 3 бодлого, 17 үндэсний хөтөлбөр, 1 менежментийн төлөвлөгөө, 1 үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт зэрэг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2020 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих нийт 7 зорилтот хөгжлийн хөтөлбөртэй байхаар туссан. Үүний нэг нь “Байгаль орчны зорилтот хөтөлбөр” байх бөгөөд энэхүү хөтөлбөрт одоо хэрэгжиж байгаа 20 гаруй төрөөс баримтлах бодлого үндэсний хөтөлбөрүүдийг нэгтгэн тусгаж боловсруулсан. Ингэснээр байгаль орчны салбарын дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн уялдаа сайжирч, давхардал хийдэл арилж хэрэгжилтийн үр дүн нэмэгдэнэ. Уг хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд “Үйл ажиллагаа 5.2.9. Тогтвортой хөгжил, хаягдалгүй эдийн засаг, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар бүх шатны сургалтын хөтөлбөрийг баяжуулж, багш, ажилчдыг чадавхжуулан байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг иргэд, хүүхэд, залууст төлөвшүүлнэ.” гэх зорилтыг тусгасан.

Түүнчлэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймаг, нийслэлийн засаг даргатай жил бүр байгуулдаг “Хамтын ажиллагааны гэрээ”-д экологийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын асуудлыг тусгаж байна.

“Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн хүрээнд /товч танилцуулая/:

- Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад мэргэжил арга зүйн болон техникийн дэмжлэг үзүүлсэн.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны болон харьяа байгууллагуудын албан хаагчдад зорилтод сургалтуудыг үе шаттай зохион байгуулж, чадавхжуулсан.
- Хүүхэд, залуучууд, иргэд, олон нийтэд байгаль орчин, экологийн боловсролыг түгээн дэлгэрүүлсэн.
- Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний зарчмыг иргэд, олон нийтэд, таниулж, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.
- Байгаль орчинд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээг ажлын байранд бий болгох, өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.
- Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг нэвтрүүлэх чиглэлээр сургалтын модуль боловсруулж байна.

Цаашид эрчимжүүлэх чиглэл:

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан тогтвортой хөгжлийн боловсролын талаарх арга хэмжээг үр дүнтэй, хүртээмжтэй хэрэгжүүлэхийн тулд хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд нягт уялдаа холбоотой, санаачилгатай ажиллах шаардлагатай байна.
- Сургууль, цэцэрлэг болон боловсролын байгууллагуудад орон нутгийн байгууллагуудаас тодорхой төсөв хөрөнгийн дэмжлэг үзүүлбэл тогтвортой хөгжлийн боловсролыг нутагшуулах арга хэмжээ орон нутгийн түвшинд үр дүнд хүрэхээр байна.
- Орон нутгийн холбогдох байгууллагууд олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдтэй тогтвортой хөгжлийн боловсролыг нутагшуулах чиглэлээр төсөл, хөтөлбөр санаачлан хамтран ажиллах шаардлагатай байна.
- Тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулж олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай.